



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/83

Улиастай

Цэрэг эргэх ажилд хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ, аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 22.3, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг тайлагнах журмын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Завхан аймгаас Зэвсэгт хүчний 123 /Ховд/, 340 /Баян-Өлгий/, Хилийн цэргийн 0245 /Увс/, 0311 /Увс/ дүгээр ангиудад алба хааж буй дайчдыг эргэх үйл ажиллагаанд 7916160 /долоон сая есөн зуун арван зургаан мянга нэг зуун жаран мянган/ төгрөг гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Л.Лхамсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2.Цэрэг эргэх ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулж дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /дэд хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ж.Хүрэлбаатар/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТСАЙХАН.

Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ны
өдрийн.....А/83.....дугаар тоот захирамжийн хавсралт

ЦЭРЭГ ЭРГЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН
ТООЦОО

№	Зардал /зүйл/-ийн нэр	Тоо /ширхэг/	Зардлын хэмжээ	Тайлбар
1	Ховд, Баян-Өлгий, Увс аймаг дахь Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиудаар ороход шаардагдах ШТМ	Нийт км-2100 Явах машин-2 Ланд-200, Фургон	1700160	
2	Албан томилолт, тавгийн идээ, замын хүнс	9 хүн-6 хоног	2066000	ЗДТГ-6 ХЖТ-2 ХМА-1
3	Аймгийн Засаг даргын гарын бэлэг	Цэрэг, түрүүч 245	1225000	
4	Алба хаалгаж буй анги салбарт аймгийн Засаг даргын зүгээс үзүүлэх дэмжлэг	Анги-3, застав-6	2925000	
	Дүн		7.916.160	

ЦЭРГИЙН ШТАБ